

Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани”)

Үйл Ажиллагааны Талаархи Шинэчилсэн Мэдээлэл

Петро Матад (AIM:MATD) нь Монгол Улсын зүүн хэсэгт байрлах ХХ талбайн Давсан Толгойн цооног дээрхи өрөмдлөгийн үйл ажиллагааныхаа талаар шинэчилсэн мэдээллийг хүргэж байна.

ДТ-2 цооногийн өрөмдлөгийн ажил 2010 оны 10 дугаар сарын 04-ний өдөр газрын гадаргуугаас доош 1,336 метрийн гүнд дууслаа. Өрмийн цамхагийг дараагийн цооног болох ДТ-3 руу нүүлгэж байна. Цооногийн геофизикийн судлагаа хийгдэж дууссан бөгөөд цооногийн дараагийн судлагааны ажилд зориулан бэхэлгээний янданг суулгаж, цементлэв.

Геологийн болон петрофизикийн урьдчилсан судлагаагаар цооногийн доод хэсгийн 275 метр дэх давхаргазүйн гурван интервал болох Цагаанцавын давхарга, түүний дээр байрлах Дээд Зүүнбаянгийн давхарга болон доод талын Шарилын давхаргуудад их хэмжээний нүүрсустөрөгч агуулагдаж байгааг харуулж байна.

Дээд Зүүнбаянгийн элсэн чулуу нь 1,025-1,041 метрийн хооронд хий, хийн ханалт болон өндөр сүвэрхэг чанартай (нүх сүвшилт 15-20 хувь) байгааг харуулсан.

Цагаанцавын давхаргаас Доод Зүүнбаянгийн тусгаарлагч чулуулгын дээд талд 1,056 метрээс өрөмдлөгт ашигладаг шавар материалаас хий илэрсэн бөгөөд Цагаанцав формацид 1,087-1,123 метрийн гүнээс авсан дээжинд [флюоресценц](#) болон тосны урсац илэрсэн байна. Цооногийн бичилтийн урьдчилсан дүн шинжилгээгээр Цагаанцавын хамгийн дээд хэсгээр элсэн чулууны сүвэрхэг чанар нь (нүх сүвшилт) 20 хувиас илүү, 1,125 метр хүртэл элсэн чулууны чанар нь буурч, формацын ул хэсэгт 1,321 метр хүртэл занар голлосон хэсэг байгааг харуулж байна. Нүүрсустөрөгчийн ханалт болон өрөмдлөгийн шаварлаг материалаас гарсан хийн дэх пентан нь нүүрсустөрөгчийн баганы ул хүртэл буюу 1,177 метрийн гүнд хүртэл үргэлжилж байна.

1,293-аас 1,298 метрийн хооронд дахь нүүрсустөрөгчийн гуравдахь бүсэд, цооногийн ёроол орчмоор Шарилын формацийн галт уулын хэмхдэсээс [флюоресценц](#) болон тосны урсац илэрсэн.

ДТ-1 болон ДТ-2 цооногууд нь Давсан Толгойн гүдэн бүтцийн (антиклинал) оройн дагуух хоёрдугаар зэргийн нэг атирааны орой болон жигүүр хэсэгт байрладаг. Энэ хоёр цооногийн талбайг хамарсан нүүрсустөрөгчийн тархалтаас харахад эдгээр цооногуудын Цагаанцавын формаци дахь нүүрсустөрөгчийн баганууд нь төстэй бөгөөд ДТ-2 цооногийнх 1,117 метрийн гүнд, ДТ-1 цооногийнх Цагаанцавын хэсгийн хамгийн гүн хэсгээс доош 33 метрийн гүнд байна. ДТ-1 цооногийн судлагаагаар Цагаанцавын давхаргыг ДТ-2 цооногийн судлагаанаас илүү судласан

бөгөөд энэхүү агуулагч давхаргын ялгааг 3 хэмжээст чичирхийллийн судлагааны мэдээллийн тайлалд тусгасан.

ДТ-1 цооногоос авсан дээжүүдийн органик материалын дулааны өөрчлөлт болон чулуулгын шинжилгээ, давхаргазүйн гурван багануудад агуулагдаж буй нүүрсустөрөгч, Зүүнбаян болон Цагаанцавын формацуудад агуулагдаж буй хий зэрэг нь Талбайн хойд талд орших Тамсагийн сав газар дахь газрын тос, хий үүсгэгч хэсгүүдийн хамгийн гүнээс Давсан Толгойн гүдэн бүтэц (антиклинал) рүү их хэмжээний шилжилт явагдсаныг харуулж байна.

Тус Компани 2010 оны хөтөлбөрийнхөө дагуу гуравдахь цооногоо (ДТ-3) Давсан Толгойн атирааны оргил хэсэг буюу ДТ-1 цооногийн атирааны оройн хэсгээс дээш 150 метрийн түвшинд өрөмдөхөөр төлөвлөж байна. Энэхүү судлагаагаар хөтөлбөрийн бусад зорилтуудаас гадна нүүрсустөрөгчийн баганы нийт өндрийг тодорхойлох юм. ДТ-3 цооногийн талбай нь ДТ-2 цооногоос урагшаа буюу баруун урагшаа 7.7 км зайд байрлах бөгөөд цооногийн нийт гүн нь 1,205 метр байна.

Даглас МакГэй ДТ-2 цооногийн ажлын талаар дүгнэж хэлэхдээ “Өрөмдлөгийн өмнө болон дунд үед тохиолдсон материал техникийн хангамж, механикын зарим хүндрэлүүдээс үл хамааран бид ДТ-2 цооногийн өрөмдлөг болон геофизикийн судлагааг хийж дуусгалаа.

“ДТ-2 цооногийн дээр дурдсан интервалуудад нүүрсустөрөгч илэрсэн нь чухал ач холбогдолтой бөгөөд Давсан Толгойн гүдэн бүтэц нь (антиклинал) нүүрсустөрөгч үүсгэгч хэсгийн (“гал зуух”) гүнээс шилжсэн газрын тос, хийгээр цэнэглэгдсэнийг болохыг дахин баталж байна.

“Хэдийгээр Цагаанцавын формац доторхи газрын тосны илрэлийн интервал нь ДТ-1 цооногтой харьцуулахад мэдэгдэхүйц их биш ч уг формацаас гадуурхи нүүрсустөрөгчийн багана болон бусад нэмэлт бүсүүд нь ихээхэн найдвар төрүүлэхээр бөгөөд тус талбайн талаархи бидний ойлголтыг нэмэгдүүллээ” гэв.

Мэдээллийг хянаж, зассан мэргэжилтэн

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүгэн хянаж, зассан болно. Доктор Күүгэн нь Хойд Америк болон олон улсын газрын тосны хайгуул, ашиглалтын салбарт 29 жил ажилласан туршлагатай Газрын тосны геологич юм.

Тэрээр Америкын Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкын Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Компанийн талаархи нэмэлт мэдээллийг :

Петро Матад Лимитед
Даглас Жэй МакГэй – Ерөнхий Гүйцэтгэх Захирал

+976 11 331099

Уэст Хаус Секьюритиз Лимитед
Ричард Бати/Питр Нортон +44 (0)20 7601 6100

Мэдээллийн хянан тохиолдуулагч нарт:

Петро Матад Лимитед компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулахад чиглэсэн группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах тухай гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол Улсын зүүн хэсэгт орших 14,250 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол Улсын төв хэсэгт орших бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан бөгөөд компанийн албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.